


МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 676.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2017 оны эхний хагас жилийн байдлаар 3,586.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 3,953.0 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 676.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь төлөвлөсөн хэмжээний 38.8 хувьтай тэнцэж байна.



Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 896.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ч орон нутгийн төсөв 122.0 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсөв 98.2 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

2017 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 28.9 хувь буюу 735.2 тэрбум төгрөгөөр, харин нийт зарлага 7.9 хувь буюу 287.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 39.8 хувиар буюу 447.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Хүснэгт 1.

	ӨО-ны мөн үеийн	2017 оны эхний хагас жилийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/			
		Төлөв.	Гүйцэт.	Хувь	Зөрүү
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-180.8	1,261.2	509.2	40.4	752.0
Засгийн газрын бонд	1,099.7	109.1	237.2	217.4	-128.1
Засгийн газрын зээл	205.0	-75.8	-153.1	201.9	77.3
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	0.0	61.5	83.0	135.0	-21.5
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	0.0	381.9	0.0	0.0	381.9
Өмч хувьчлал	0.0	7.0	0.3	3.8	6.7
НИЙТ ДҮН	1,123.9	1,744.8	676.5	38.8	1,068.3

Эх сурвалж: Сангийн яам

2017 оны эхний хагас жилд гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 89.0 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 1,978.4 тэрбум, богино хугацаат

дотоод бондын үндсэн төлбөрт 283.9 тэрбум төгрөгийг тус тус төлж, 390.5 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл авч, Засгийн газрын 826.7 тэрбум төгрөгийн урт хугацаат дотоод, 1,498.2 тэрбум төгрөгийн урт хугацаат гадаад, 1,174.7 тэрбум төгрөгийн богино хугацаат дотоод бондыг тус тус арилжаалсан гүйцэтгэлтэй байна.

1. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 3,276.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 28.9 хувиар буюу 735.2 тэрбум төгрөгөөр өсч, мөн орлогын төлөвлөгөө 4.7 хувиар буюу 145.9 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

2017 оны эхний хагас жилийн байдлаар улсын төсвийн орлого 0.4 хувиар буюу 9.3 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 3.5 хувиар буюу 41.0 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын төсөв 7.7 хувиар буюу 72.0 тэрбум төгрөгөөр тус тус төвөвлөснөөс давж биелжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн орлого 655.8 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн орлого 151.7 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн орлого 155.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Нэгдсэн төсвийн орлогын 2017 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, төсвийн шатлалаар
Хүснэгт 2. /тэрбум төгрөг/


Ангилал	Нэгдсэн төсөв		Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС	
	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,437.9	3,586.8	2,588.8	2,601.2	1,185.9	1,226.9	938.3	1,010.4
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	119.3	113.0	119.3	113.0	0.0	0.0	0.0	0.0
ИРЭЭДҮЙН ӨВ САН	187.9	197.4	187.9	197.4	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,130.6	3,276.5	2,281.5	2,290.8	1,185.9	1,226.9	938.3	1,010.4
Татварын орлого	2,549.4	2,817.1	1,613.6	1,764.0	408.1	438.2	644.7	716.7
Орлогын албан татвар	643.7	703.3	396.5	439.6	247.2	263.7	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	527.6	614.9	0.0	0.0	0.0	0.0	644.7	716.7
Хөрөнгийн албан татвар	65.7	65.2	0.0	0.0	65.7	65.2	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	611.8	712.1	611.8	712.1	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	245.8	208.6	245.8	208.6	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	4.6	6.0	4.6	6.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	191.5	214.5	191.5	214.5	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	258.8	292.6	163.5	183.3	95.3	109.3	0.0	0.0
Татварын бус орлого	581.3	459.3	667.9	526.8	777.8	788.7	293.6	293.6
Нийтлэг татварын бус орлого	488.2	444.1	420.3	364.4	67.9	79.7	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.2	0.4	0.0	0.0	0.2	0.4	0.0	0.0
Тусламжийн орлого	92.9	14.9	184.4	104.5	1.0	0.0	293.6	293.6
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0	63.2	57.9	708.6	708.6	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын 86.0 хувийг татварын орлого, 14.0 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 25.9 хувиар буюу 579.5 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 51.3 хувиар буюу 155.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


График 2. Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /хувиар/



Татварын орлого 2,817.1 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 10.5 хувиар буюу 267.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Татварын орлогын 25.0 хувийг орлогын албан татвар, 25.3 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 21.8 хувийг нийгмийн даатгалын орлого, 7.4 хувийг онцгой албан татвар, 7.7 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 2.3 хувийг хөрөнгийн албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 10.3 хувийг бусад татвар бүрдүүлж байна.

График 3. Татварын орлого /тэрбум төгрөг/




2017 оны эхний хагас жилийн байдлаар нэгдсэн төсвийн орлогын албан татвар 9.3 хувиар буюу 59.6 тэрбум, нийгмийн даатгалын орлого 16.6 хувиар буюу 87.3 тэрбум, нэмэгдсэн өртгийн албан татвар 16.4 хувиар буюу 100.4 тэрбум, тусгай зориулалтын орлого 29.4 хувиар буюу 1.4 тэрбум, гадаад худалдааны орлого 12.0 хувиар буюу 23.0 тэрбум, бусад татвар 13.0 хувиар буюу 37.0 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс давж биелжээ. Харин онцгой албан татвар 15.1 хувиар буюу 37.2 тэрбум, хөрөнгийн албан татвар 0.7 хувиар буюу 0.5 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Татварын бус орлого 459.3 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 51.3 хувиар буюу 155.7 тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч орлогын төлөвлөгөө 21.0 хувиар буюу 121.9 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

Татварын бус орлогын төлөвлөгөө дутуу биелэхэд гадаад хандив, тусламжийн орлого 78.0 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 62.0 тэрбум, газрын тосны орлого 17.7 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь голлон нөлөөлжээ.

График 4. Татварын бус орлогын бүтэц /хувиар



Татварын бус орлогын 96.7 хувийг нийтлэг татварын бус орлого, 3.2 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого бүрдүүлж байна. Нийтлэг татварын бус орлогын 38.6 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 22.1 хувийг газрын тосны орлого, 16.1 хувийг навигацийн орлого, 2.7 хувийг хүүгийн орлого, 4.4 хувийг торгуулийн орлого, 8.8 хувийг бусад орлого, 7.1 хувийг хувьцааны ногдол ашиг, 0.2 хувийг түрээсийн орлого тус тус эзэлж байна.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн дагуу 20 төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээсний 2 төсвийн ерөнхийлөн захирагч орлогын төлөвлөгөөгөө давуулан биелүүлж, 18 төсвийн ерөнхийлөн захирагч дутуу төвлөрүүлсэн байна.

2017 оны эхний хагас жилийн төсвийн ерөнхийлөн захирагч,
түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого

Хүснэгт 3.

/сая төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	ӨО-ны мөн үеийн	2017 оны эхний хагас жил			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сангийн сайд	1,321,918.7	2,343,357.1	2,206,370.8	136,986.4	94.2
Татварын ерөнхий газар		1,205,914.1	1,287,248.8	-81,334.7	106.7
Гаалийн ерөнхий газар		779,073.5	831,396.2	-52,322.7	106.7
Сангийн яам	11,577.7	262,203.4	5,309.9	256,893.5	2.0
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	2,500.0	58,910.4	54,506.0	4,404.4	92.5
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	2,422.0	33,936.2	26,250.6	7,685.7	77.4
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	3,249.9	3,319.5	1,659.3	1,660.3	50.0
Монгол Улсын Их Хурлын дарга	761.5	2,717.8	1,412.9	1,304.9	52.0
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	761.5	2,717.8	1,412.9	1,304.9	52.0
Монгол Улсын Ерөнхий сайд	2,197.0	18,955.9	9,853.9	9,102.0	52.0
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар		14,633.4	8,101.3	6,532.1	55.4
Бүх нийтийн үүргийн сан		900.0	0.0	900.0	0.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	2,197.0	3,422.5	1,752.6	1,669.9	51.2
Монгол Улсын Ерөнхий аудитор	0.0	549.1	289.5	259.6	52.7
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих		549.1	289.5	259.6	52.7
Монгол Улсын Шадар сайд	5,057.3	12,710.6	7,247.9	5,462.6	57.0
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	82.1	189.1	304.6	-115.5	161.1
Стандартчлал, хэмжил зүйн газар	352.1	1,151.3	1,549.5	-398.2	134.6
Хилийн мэргэжлийн хяналтын алба		300.0	0.0	300.0	0.0
Аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар		675.0	1,627.5	-952.5	241.1
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих		5,606.2	3,621.7	1,984.4	64.6
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	4,623.1	4,789.1	144.5	4,644.5	3.0
Хууль зүй, дотоод хэргийн сайд	8,580.2	7,156.0	20,140.5	-12,984.5	281.4
Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар		7,950.0	10,313.3	-2,363.3	129.7
Цагдаагийн ерөнхий газар	706.6	1,743.8	1,182.4	561.3	67.8
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт		-20,600.7	0.0	-20,600.7	0.0
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгүүдэд олгох санхүүжилтийн орлого	389.0	1,518.8	0.0	1,518.8	0.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	7,484.6	16,544.1	8,644.8	7,899.4	52.3
Гадаад харилцааны сайд	2,406.7	8,120.6	11,134.3	-3,013.8	137.1
Дипломат төлөөлөгчийн газрууд	2,160.8	6,570.6	10,359.3	-3,788.8	157.7
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	245.9	1,550.0	775.0	775.0	50.0
Зам тээвэр, хөгжлийн сайд	39,792.5	81,619.0	75,819.9	5,799.2	92.9
Иргэний нисэхийн ерөнхий газар	38,000.0	71,346.1	71,310.8	35.3	100.0
Монгол Улсын далайн захиргаа	20.0	95.0	95.0	0.0	0.0
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих		8,277.1	3,462.8	4,814.4	41.8

Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,772.5	1,900.8	951.3	949.5	50.0
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	0.1	152,900.9	128,456.3	24,444.6	84.0
Ашигт малтмал, газрын тосны газар	70,283.2	142,590.9	123,424.1	19,166.7	86.6
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих		3,352.3	2,377.5	974.8	70.9
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,293.2	6,957.8	2,654.6	4,303.1	38.2
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	21,729.1	79,634.6	62,397.1	17,237.5	78.4
Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар		174.0	0.0	174.0	0.0
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгүүдэд олгох санхүүжилтийн орлого	190.1	263.6	0.0	263.6	0.0
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих		13,739.0	8,888.6	4,850.4	64.7
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	21,539.0	65,458.0	53,508.5	11,949.5	81.7
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	17,858.1	133,672.7	116,716.3	16,956.3	87.3
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	383.0	26,148.4	33,965.3	-7,817.0	129.9
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	11,856.4	7,126.1	5,641.5	1,484.6	79.2
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	5,618.7	100,398.2	77,109.5	23,288.7	76.8
Эрүүл мэндийн сайд	84,086.1	127,007.1	14,064.4	112,942.7	11.1
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгүүдэд олгох санхүүжилтийн орлого	74,425.1	88,459.2	0.0	88,459.2	0.0
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих		13,875.4	1,716.3	12,159.1	12.4
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	9,661.0	24,672.5	12,348.1	12,324.3	50.0
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	2,783.6	1,099.9	964.5	135.4	87.7
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	575.5	819.4	819.4	0.0	100.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	2,208.1	280.5	145.1	135.4	51.7
Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	82.1	1,023.7	528.6	495.0	51.6
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих		881.2	457.4	423.8	51.9
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	82.1	142.5	71.3	71.3	50.0
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	2,423.1	33,105.3	21,785.2	11,320.1	65.8
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих		28,131.9	19,172.0	8,959.9	68.2
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	2,423.1	4,973.4	2,613.3	2,360.1	52.5
Барилга, хот байгуулалтын сайд	0.0	31,998.9	5,360.4	26,638.5	16.8
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар		743.6	583.2	160.4	78.4
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих		31,255.3	4,777.2	26,478.1	15.3
Батлан хамгаалахын сайд	-23,052.6	56,396.5	26,907.5	29,489.0	47.7
Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгүүдэд олгох санхүүжилтийн орлого	2,405.3	2,262.0	0.0	2,262.0	0.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	20,647.3	54,134.5	26,907.5	27,227.0	49.7
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	-30.9	60.0	17.5	42.5	29.2
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	30.9	60.0	17.5	42.5	29.2
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	-798.0	822.4	411.2	411.2	50.0
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	798.0	822.4	411.2	411.2	50.0
Үндэсний статистикийн хорооны дарга	0.0	595.7	325.9	269.8	54.7
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих		589.7	322.9	266.8	54.8

Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого		6.0	3.0	3.0	50.0
Эрчим хүчний сайд	0	5,435.9	1,811.9	3,623.9	33.3
Гадаад тусламжийн орлогоос санхүүжих		5,435.9	1,811.9	3,623.9	33.3

Эх сурвалж: Сангийн яам

2. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 4,875.5 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 81.1 хувийг ашиглаж, 922.5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн хэмжээнээс дутуу гүйцэтгэлтэй гарчээ.

Нэгдсэн төсвийн зарлагын 2017 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, төсвийн шатлалаар
Хүснэгт 4. /тэрбум төгрөг/

	Нэгдсэн төсөв		Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,875.5	3,953.0	3,683.1	3,187.4	1,518.3	1,104.9	949.1	912.2
НИЙТ ЗАРЛАГА	4,716.1	3,868.4	3,545.0	3,109.9	1,497.1	1,097.9	949.1	912.2
УРСГАЛ ЗАРДАЛ	3,829.	3,352.8	2,991.3	2,669.6	1,164.2	1,022.6	949.1	912.2
Бараа, ажил үйлчилгээний зардал	1,776.1	1,490.7	1,061.6	859.3	792.6	705.2	9.7	9.1
Зээлийн үйлчилгээний төлбөр	582.6	523.1	582.6	523.1				
Татаас	167.0	136.7	360.8	356.1	44.9	39.2	65.9	35.0
Урсгал шилжүүлэг	1,303.9	1,202.3	986.3	931.0	326.7	278.1	884.6	868.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	886.5	515.6	553.6	440.3	332.9	75.3		
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	159.4	84.6	138.2	77.6	21.2	7.0		
НИЙТ ТЭНЦЭЛ	-1,744.8	-676.5	-1401.6	-896.6	-332.4	-122.0	-10.8	98.2

Эх сурвалж: Сангийн яам

2017 оны эхний хагас жилийн байдлаар улсын төсвийн зарлага 495.7 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 413.4 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 36.9 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан байна. Улсын төсвийн нийт зардал өмнөх оны мөн үеэс 527.6 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зардал 109.3 тэрбум төгрөгөөр тус тус өсч, орон нутгийн төсвийн зардал 5.7 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл өнгөрсөн оны мөн үеэс 7.9 хувиар буюу 287.9 тэрбум төгрөгөөр өсөхөд зээлийн үйлчилгээний төлбөр 154.1 тэрбум төгрөг буюу 41.8 хувиар, татаас 29.5 тэрбум төгрөгөөр буюу 8.0 хувиар, урсгал шилжүүлэг 151.0 тэрбум төгрөг буюу 13.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Харин хөрөнгийн зардал 2.1 хувиар буюу 11.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл
/Зардлын эдийн засгийн ангиллаар/

Хүснэгт 5.

	ӨО-ны	2017 оны эхний хагас жил

Зардлын зүйл	мөн үеийн	Төлөв	Гүйцэт	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,665.1	4,875.5	3,953.0	81.1	922.5
НИЙТ ЗАРЛАГА	3,646.0	4,716.1	3,868.4	82.0	847.7
УРСГАЛ ЗАРДАЛ	3,119.3	3,829.6	3,352.8	87.5	476.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,490.3	1,776.1	1,490.7	83.9	285.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	889.5	952.0	919.8	96.6	32.3
Үндсэн цалин	788.8	780.0	768.3	98.5	11.7
Нэмэгдэл	42.6	101.5	89.7	88.3	11.8
Унаа хоолны хөнгөлөлт	16.8	20.4	18.5	90.6	1.9
Урамшуулал	20.9	26.4	23.0	87.2	3.4
Гэрээт ажлын хөлс	20.3	23.8	20.3	85.4	3.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81.7	87.8	83.0	94.5	4.8
Тэтгэврийн даатгал	81.7	54.6	51.7	94.7	2.9
Тэтгэмжийн даатгал	0.0	6.8	6.5	94.5	0.4
ҮОМШӨ-ний даатгал	0.0	6.4	6.1	95.2	0.3
Ажилгүйдлийн даатгал	0.0	1.5	1.5	96.1	0.1
Эрүүл мэндийн даатгал	0.0	18.4	17.2	93.7	1.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	115.0	136.2	117.8	86.5	18.4
Гэрэл, цахилгаан	21.8	24.3	22.0	90.3	2.3
Түлш, халаалт	74.7	87.9	74.7	85.0	13.2
Цэвэр, бохир ус	10.1	12.7	10.5	82.3	2.2
Байрны түрээс	8.4	11.3	10.7	94.6	0.6
Хангамж, бараа материалын зардал	56.3	64.6	52.1	80.8	12.4
Бичиг хэрэг	4.4	5.2	4.5	86.5	0.7
Тээвэр, шатахуун	21.8	22.0	19.9	90.7	2.0
Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	5.7	6.2	5.2	84.1	1.0
Ном, хэвлэл	1.2	4.1	0.7	17.1	3.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19.0	22.2	17.9	80.6	4.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4.1	5.0	4.0	80.2	1.0
Нормативт зардал	117.5	136.8	114.4	83.7	22.3
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	48.1	60.0	52.0	86.7	8.0
Хоол, хүнс	50.2	56.0	48.4	86.4	7.6
Нормын хувцас, зөөлөн эдлэл	19.2	20.8	14.0	67.4	6.8
Эд хогшил, урсгал засварын зардал	21.1	31.4	23.6	75.1	7.8
Багаж, техник, хэрэгсэл	5.6	10.8	7.8	72.6	3.0
Тавилга	2.5	1.2	1.0	79.4	0.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.3	0.7	0.4	57.2	0.3
Урсгал засвар	12.6	18.6	14.3	77.0	4.3
Томилолт, зочны зардал	9.0	12.2	9.1	74.2	3.2
Гадаад албан томилолт	2.6	4.0	3.5	88.1	0.5
Дотоод албан томилолт	5.4	7.0	4.6	66.0	2.4
Зочин төлөөлөгч хүлээн авах	1.0	1.2	0.9	75.9	0.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	161.1	266.0	138.0	51.9	127.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	133.8	243.4	123.7	50.8	119.7

үйлчилгээний төлбөр хураамж					
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.6	0.9	0.6	61.5	0.4
Даатгалын үйлчилгээ	4.9	6.8	6.5	94.5	0.4
Тээврийн хэрэгслийн татвар	0.4	0.6	0.4	72.5	0.2
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.1	0.2	0.1	73.1	0.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1.9	5.2	2.7	52.2	2.5
Газрын төлбөр	0.5	0.9	0.6	67.2	0.3
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.3	0.9	0.6	70.3	0.3
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3.5	7.0	2.8	40.1	4.2
Бараа үйлчилгээний бусад зардал	120.9	177.0	115.8	65.5	61.1
Бараа үйлчилгээний бусад зардал	107.4	155.8	99.2	63.7	56.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13.4	21.2	16.7	78.8	4.5
ХҮҮ	369.0	582.6	523.1	89.8	59.5
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	132.0	268.3	234.0	87.2	34.4
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	237.0	314.3	289.2	92.0	25.1
ТАТААС	107.2	167.0	136.7	81.9	30.3
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	7.2	13.0	12.8	98.6	0.2
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	100.0	154.0	123.9	80.5	30.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,152.9	1,303.9	1,202.3	92.2	101.7
Засгийн газрын урсгал шилжүүлэг	34.0	55.3	47.2	85.3	8.1
Засгийн газрын дотоод шилжүүлэг	29.7	51.6	44.4	86.2	7.1
Засгийн газрын гадаад шилжүүлэг	4.3	3.7	2.7	73.1	1.0
Бусад урсгал шилжүүлэг	1,118.9	1,248.6	1,155.1	92.5	93.5
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	687.3	792.0	778.5	98.3	13.5
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	285.0	239.9	220.7	92.0	19.2
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4.7	3.4	2.2	65.4	1.2
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	96.0	114.3	78.0	68.2	36.3
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38.5	53.4	34.4	64.4	19.0
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэ	5.1	42.3	39.0	92.2	3.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2.3	3.3	2.3	68.5	1.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	526.7	886.5	515.6	58.2	370.9
Барилга байгууламж	284.9	621.8	421.0	67.7	200.7
Их засвар	63.5	30.8	10.6	34.6	20.1
Тоног төхөөрөмж	15.4	65.4	22.4	34.3	43.0
Бусад хөрөнгө	50.4	144.4	42.0	29.1	102.4
Стратегийн нөөц хөрөнгө	4.7	24.1	19.5	80.9	4.6
Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	107.8	0.0	0.0	0.0	0.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	19.1	159.4	84.6	53.1	74.8
Эргэж төлөгдөх зээл	5.5	136.8	59.3	43.3	77.6
Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	13.7	22.6	25.3	112.2	-2.8


Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувийн жин 84.8 хувь болж, өнгөрсөн оны мөн үеэс 0.3 пунктээр буурсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 84.8 хувийг буюу 3,352.0 тэрбум төгрөгийг урсгал зардал эзэлж байгаагийн 44.4 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 15.6 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 4.1 хувийг татаас, 35.9 хувийг урсгал шилжүүлгийн зардал бүрдүүлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 233.5 тэрбум төгрөгөөр өсөхөд зээлийн үйлчилгээний төлбөр 154.1 тэрбум, татаас 29.5 тэрбум, урсгал шилжүүлэг 49.4 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

График 5. Урсгал зардлын бүтэц /хувиар/



Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар 31 төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах эрхийг баталсан бөгөөд улсын төсвийн 2017 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр тэдгээрийн батлагдсан төсөв 463.8 тэрбум төгрөгөөр буюу 16.3 хувиар дутуу зарцуулагдсан байна.

Улсын төсвийн нийт зарлагын 21.7 хувийг Сангийн сайдын, 20.8 хувийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын, 9.6 хувийг Эрүүл мэндийн сайдын, 17.6 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 6.7 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, 2.8 хувийг Батлан хамгаалахын сайдын, 9.3 хувийг Зам тээврийн хөгжлийн сайд, 2.9 хувийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын, үлдэх 8.8 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын багцын зарлага эзэлж байна.

Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

Хүснэгт 6.

/сая төгрөг/

Төвийн ерөнхийлөн захирагч	2017 оны эхний хагас жил			
	Төл	Гүйц	Зөрүү	Хувь
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	2,174.6	1,864.7	309.9	85.7
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	12,922.5	10,720.0	2,202.5	83.0
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	77,640.6	31,457.8	46,182.8	40.5
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	6,532.8	4,624.4	1,908.3	70.8
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	27,825.0	26,176.3	1,648.7	94.1
САНГИЙН САЙД	608,374.0	514,736.1	93,637.9	84.6
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	94,870.0	66,336.6	28,533.3	69.9
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	276,715.2	227,693.4	49,021.8	82.3
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	816.4	603.6	212.8	73.9
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	1,945.4	1,422.7	522.7	73.1
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	21,001.9	18,961.1	2,040.8	90.3
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	11,672.1	10,810.3	861.8	92.6

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	900.5	830.9	69.6	92.3
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	4,308.4	3,385.7	922.7	78.6
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	3,369.2	2,419.4	949.8	71.8
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	1,173.8	1,064.8	109.0	90.7
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	365.1	360.0	5.1	98.6
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА	273.8	246.3	27.5	90.0
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	53,791.6	36,447.4	17,344.1	67.8
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	12,356.8	4,377.8	7,979.0	35.4
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	327.5	299.4	28.1	91.4
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	5,247.7	3,406.4	1,841.3	64.9
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	37,524.2	18,058.9	19,465.3	48.1
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	198,516.7	160,290.8	38,225.9	80.7
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	25,773.9	8,752.9	17,021.0	34.0
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	565,346.8	493,743.9	71,602.9	87.3
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	181,592.7	220,253.8	-38,661.1	121.3
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	9,989.7	5,239.4	4,750.3	52.4
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	98,263.2	68,302.7	29,960.5	69.5
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	26,191.4	16,660.0	9,531.4	63.6
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	473,343.3	417,788.3	55,554.9	88.3
НИЙТ ЗАРДАЛ	2,841,146.8	2,377,335.9	463,811.0	83.7

Эх сурвалж: Сангийн яам

3. **Хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээ** Нийт хөрөнгийн зардалд 515.6 тэрбум төгрөг зарцуулж, 58.2 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

4. **Нийгмийн даатгалын сан**

Нийгмийн даатгалын сангийн орлого:



Нийгмийн даатгалын санд 2017 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр нийт 1,010.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төсөвлөснөөс 7.7 хувиар буюу 72.0 тэрбум төгрөгөөр давж биелэснээр орлогын гүйцэтгэл 107.0 хувьтай гарчээ.

Нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 155.6 тэрбум төгрөгөөр буюу 18.2 хувиар өссөн байна. Тус санд улсын төсвөөс 293.6 тэрбум төгрөгийн татаас олгожээ.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг дараахь байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд: Тэтгэврийн даатгалын санд 715.4 тэрбум төгрөг, Тэтгэмжийн даатгалын санд 52.3 тэрбум төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын санд 65.0 тэрбум

төгрөг, Ажилгүйдлийн даатгалын санд 22.5 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын санд 165.4 тэрбум төгрөгийг тус тус хуваарилжээ.

Нийгмийн даатгалын сангийн зарлага:



2017 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангийн нийт зардалд 949.1 тэрбум төгрөг төлөвлөснөөс тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон бусад зардалд нийт 912.2 тэрбум төгрөгийг зарцуулж, 96.1 хувийн гүйцэтгэлтэй буюу 48.2 тэрбум төгрөгийн хэмнэлт гарчээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн нийт зардал 109.3 тэрбум төгрөгөөр буюу 13.6 хувиар нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 912.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 109.3 тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 86.9 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 15.0 тэрбум, ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 7.6 тэрбум, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 4.4 тэрбум, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 1.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.



2017 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч иргэдийн тэтгэвэрт болон бусад зардалд нийт 702.6 тэрбум төгрөг, Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэн ба амаржсаны, оршуулгын тэтгэмж болон бусад зардалд 47.3 тэрбум төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын

тэтгэвэр, сувиллын болон бусад зардалд 22.3 тэрбум төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид болон бусад зардалд 19.1 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын

сангаас эмнэлэгийн тусламж, үйлчилгээ, рашаан сувилал, эмийн үнийн хөнгөлөлт болон бусад зардалд 126.7 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

5. Орон нутгийн төсөв

Орон нутгийн төсвийн зарлага 342.2 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.


2017 оны эхний хагас жилийн байдлаар орон нутгийн төсвийн орлого 1,226.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 3.5 хувиар буюу 41.0 тэрбум төгрөгөөр илүү төвлөрч, нийт зарлага 1,104.9 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 27.2 хувиар буюу 413.4 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орон нутгийн төсвийн орлого 14.1 хувиар буюу 151.7 тэрбум төгрөгөөр өсч, харин нийт зарлага 0.5 хувиар буюу 5.7 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогын 42.2 хувийг орон нутгийн төсвийн орлого, 6.1 хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 49.2 хувийг тусгай зориулалтын шилжүүлэг, 2.4 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг эзэлж байна.

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 66.2 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгожээ.

График 10. Орон нутгийн төсвийн орлогын бүтэц /хувиар/



Аймгуудад улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг болон аймгийн тусгай зориулалтын болон орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг

Хүснэгт 9.

	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ			ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ			ОН-ИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ		
	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь	Олгох	Олгосон	Хувь
Архангай	6,762.9	6,762.9	100.0	22,703.7	22,703.7	100.0	1,101.6	1,101.6	100.0
Баян-Өлгий	5,925.9	5,925.9	100.0	28,714.7	28,714.7	100.0	867.8	867.8	100.0
Баянхонгор	6,339.4	6,339.4	100.0	21,708.1	21,708.1	100.0	1,189.5	1,189.5	100.0
Булган	0.0	0.0	0.0	16,663.7	16,663.7	100.0	1,015.5	1,015.5	100.0
Говьсүмбэр	0.0	0.0	0.0	4,575.1	4,575.1	100.0	693.6	693.6	100.0
Говь-Алтай	4,673.2	4,673.2	100.0	18,926.5	18,926.5	100.0	1,246.2	1,246.2	100.0
Дархан-Уул	0.0	0.0	0.0	20,172.6	20,172.6	100.0	1,053.1	1,053.1	100.0
Дорноговь	0.0	0.0	0.0	15,830.2	15,830.2	100.0	1,475.8	1,475.8	100.0

Дорнод	1,428.8	1,428.8	100.0	17,136.4	17,136.4	100.0	1,203.4	1,203.4	100.0
Дундговь	3,271.5	3,271.5	100.0	12,993.4	12,993.4	100.0	1,101.4	1,101.4	100.0
Завхан	5,351.0	5,351.0	100.0	19,445.9	19,445.9	100.0	883.0	883.0	100.0
Орхон	0.0	0.0	0.0	17,591.6	17,591.6	100.0	1,137.8	1,137.8	100.0
Өвөрхангай	6,528.4	6,528.4	100.0	26,260.7	26,260.7	100.0	1,286.5	1,286.5	100.0
Өмнөговь	0.0	0.0	0.0	15,410.3	15,410.3	100.0	2,283.0	2,283.0	100.0
Сүхбаатар	2,908.4	2,908.4	100.0	16,407.5	16,407.5	100.0	775.4	775.4	100.0
Сэлэнгэ	2,000.0	2,000.0	100.0	25,029.4	25,029.4	100.0	1,321.9	1,321.9	100.0
Төв	4,331.1	4,331.1	100.0	24,787.0	24,787.0	100.0	1,005.8	1,005.8	100.0
Увс	6,331.8	6,331.8	100.0	24,419.7	24,419.7	100.0	902.2	902.2	100.0
Улаанбаатар	0.0	0.0	0.0	181,979.2	181,979.2	100.0	5,961.6	5,961.6	100.0
Ховд	4,417.7	4,417.7	100.0	21,932.2	21,932.2	100.0	901.8	901.8	100.0
Хөвсгөл	10,222.7	10,222.7	100.0	30,791.8	30,791.8	100.0	1,176.8	1,176.8	100.0
Хэнтий	4,824.0	4,824.0	100.0	20,079.6	20,079.6	100.0	1,162.9	1,162.9	100.0
ДҮН	75,316.8	75,316.8	100.0	603,559.2	603,559.2	100.0	29,746.7	29,746.7	100.0

Эх сурвалж: Сангийн Яам

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, газрын харилцаа, кадастр, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ, нийтийн биеийн тамир зэрэг Засгийн газрын чиг үүргийг орон нутаг төлөөлөн хэрэгжүүлэхэд нийт 603.6 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг аймгуудад олгожээ.

2017 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр аймгуудын орон нутгийн хөгжлийн санд төсөвлөсөн хэмжээгээр буюу 29.7 тэрбум төгрөгийг шилжүүлсэн байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2017 оны эхний хагас жилийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж үзэхэд дараахь дүгнэлт өгөхөөр байна. Үүнд:

Төсвийн орлогын хувьд: Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого эхний хагас жилийн байдлаар сар бүрийн орлогын төлөвлөгөө давж биелсэн, мөн өмнөх оны мөн үеэс өсөлттэй гарч, төсөвт эерэг нөлөөлөл бий болж байна.

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1 дүгээр сард 105.3 хувь, 2 дугаар сард 100.0 хувь, 3 дугаар сард 103.1 хувь, 4 сард 104.1 хувь, 5 дугаар сард 103.1 хувь, 6 сард 103.5 хувийн биелэлттэй гарсан байна.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеэс байнга өссөн үзүүлэлттэй байна. **Тухайлбал:** 1 дүгээр сард 31.4 хувь, 2 дугаар сард 35.9 хувь, 3 дугаар сард 37.3 хувь, 4 дүгээр сард 26.4 хувь, 5 дугаар сард 27.9 хувь, 6 дугаар сард 14.1 хувиар нэмэгдсэн байна.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө биелэхэд татварын орлогын өсөлт ихээхэн нөлөөлсөн байна. Татварын орлого 2017 он гарснаас хойш сар бүр давж биелэгдсэн байна. Тухайлбал; 2017 оны 1 сард 0.8 хувь байснаа тогтвортой өсч, эхний хагас жилийн байдлаар 10.5 хувиар давж биелжээ. Татварын орлогын хувьд онцгой албан татвараас бусад бүх төрлийн татварын төлөвлөгөө биелэсэн байна.

- Татварын бус орлогын төлөвлөгөө 1 дүгээр сард 31.6 хувиар давж биелэсэн хэдий ч 2-6 сард 6.8 – 21.0 хувиар дутуу биелсэн байна. Үүнд төсөвт байгууллагын өөрийн орлого, гадаад хандив тусламжийн орлого, газрын тосны орлого болон навигацийн орлогууд тодорхой хувиар тасарсан нь нөлөөлжээ.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зарлага эхний хагас жилийн байдлаар сар бүр дутуу зарцуулагдаж өссөн дүнгээр хэмнэгдсэн байна.

- Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэл төсөвлөснөөс 1-6 сард 21.4-28.9 хувиар дутуу зарцуулагдан хэмнэлт үүссэн байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА